



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 30 өдөр

Дугаар А/531

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 14/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Чанартай боловсрол" дэд хөтөлбөрийн 3.3.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Чандмань сумын Ерөнхий боловсролын сургуульд ардын урлагийн дугуйлан хичээллүүлэх материаллаг баазыг нэмэгдүүлэхэд 3,000,000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Зардалд зарцуулагдах нийт 3,000,000 (гурван сая) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 5.1 дэх заалт, Боловсролын салбарын хөтөлбөр "Чанартай боловсрол" дэд хөтөлбөрөөс тооцож гаргахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбат)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Ганболд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Х.БАТБОЛД

8400001 1301

Zah A/531 Kh

Засаг даргын 2024 оны  
07 дугаар сарын 30-ны өдрийн  
А/531 дүгээр захирамжийн хавсралт



АРДЫН УРЛАГИЙН ДУГУЙЛАН ХИЧЭЭЛЛҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ  
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТӨСӨВ

Д/д	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Хуур	ш	30	50,000	1,500,000
2	Нуман хуур	ш	10	150,000	1,500,000
ДҮН					3,000,000

-оОо-